МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Судалгааны төрөл: **Лавлагаа, мэдээлэл**

Судалгааны код: **СТ-25/410**

Хугацаа: **2025.09.10**

Захиалагч:	УИХ-ын гишүүн Ж.Баярмаа
Хянасан:	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
Судалгаа удирдсан:	Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судлаач:	Судалгааны хэлтсийн ахлах референт О.Нарантуяа

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГЫН ТОВЬЁГ

УДИРТГАЛ.....2

НЭГ. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕД МЭТГЭЛЦЭЭН ЗААВАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХААР ХУУЛЬЧИЛСАН УЛС ОРНУУД (ТАВИГДАХ ШААРДЛАГА) 3

ХОЁР. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ШТАБЫН АЖИЛТНУУДЫН ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛЛЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ 8

ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭГДСЭН СОНИН СЭТГҮҮЛ ГАРГАДАГ УЛС ОРНУУД 12

СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....15

ЭХ СУРВАЛЖ.....16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Солонгосын сонгуулийн өргөн нэвтрүүлгийн мэтгэлцээний хорооноос зохион байгуулдаг мэтгэлцээний төрлүүд 6
Хүснэгт 2 Японы сонгуулийн сурталчилгаанд оролцогчдод олгох бодит зардлын нөхөн төлбөрийн хэмжээ (нэг өдрөөр)..... 11
Хүснэгт 3 Японы сонгуулийн сурталчилгаанд оролцогчдод олгох урамшууллын хэмжээ (нэг өдрөөр) 11
Хүснэгт 4 Японы сонгуулийн сурталчилгааны туслах ажилтанд олгох мөнгөн дүнгийн хэмжээ (Бодит зардлын нөхөн төлбөр, нэг шөнөөр)..... 11

УДИРТГАЛ

“Сонгуулийн сурталчилгааны зарим зохицуулалтын талаарх лавлагаа, мэдээлэл”-ийг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн (ПСХХ)-д гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь “сонгуулийн сурталчилгааны үед мэтгэлцээн заавал зохион байгуулахаар хуульчилсан улсууд, тавигдах шаардлага, нэр дэвшигчийн сонгуулийн штабын ажилтнуудын цалин хөлс, урамшуулал болон нэр дэвшигчийн сурталчилгааны нэгдсэн сонин сэтгүүл гаргадаг улсуудын талаар лавлагаа, мэддээлэл гаргах.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд сонгуулийн сурталчилгааны үед мэтгэлцээн заавал зохион байгуулахаар хуульчилсан улс, тавигдах шаардлага (Австрали, Франц, Герман, Мексик, Их Британи, АНУ, БНСУ), нэр дэвшигчийн сонгуулийн штабын ажилтнуудын цалин хөлс, урамшуулал (БНСУ, Япон, Их Британи) болон нэр дэвшигчийн сурталчилгааны нэгдсэн сонин сэтгүүл гаргадаг улс (БНСУ, Япон)-ын туршлагын талаар судлав.

Судалгааны арга зүй:

Судалгаанд сонгож авсан улсуудын холбогдох хууль тогтоомжийг харьцуулан судлах үүднээс харьцуулсан шинжилгээний арга зүй, хууль зүйн баримт бичгийн судалгааны аргыг ашигласан болно.

Судалгааны ажлын бүтэц:

Судалгаа нь нэгд, сонгуулийн сурталчилгааны үед мэтгэлцээн заавал зохион байгуулахаар хуульчилсан улс орнууд (тавигдах шаардлага), хоёрт, нэр дэвшигчийн сонгуулийн штабын ажилтнуудын цалин хөлс, урамшуулал, гуравт, нэр дэвшигчийн сурталчилгааны нэгдсэн сонин сэтгүүл гаргадаг улсуудын талаар судалсан болно.

Түлхүүр үг:

Монгол: сонгуулийн сурталчилгаа, мэтгэлцээн, ухуулагч, нэгдсэн сонин, сэтгүүл.

Англи: election campaign, debate, canvasser, campaigner, consolidated newspaper, magazine.

НЭГ.СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕД МЭТГЭЛЦЭЭН ЗААВАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХААР ХУУЛЬЧИЛСАН УЛС ОРНУУД (ТАВИГДАХ ШААРДЛАГА)

Парламентын болон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны үеэр мэтгэлцээн заавал зохион байгуулахыг хуульчилсан улс орон судалгаанд хамрагдсан улс орнуудад хараахан байхгүй байна. Гэсэн хэдий ч зарим улс оронд, ялангуяа ерөнхийлөгчийн сонгуулийн үед нэр дэвшигчдийн хооронд мэтгэлцээнийг тогтмол зохион байгуулах улс төрийн уламжлал тогтсон байна. Ийм мэтгэлцээнийг сонгуулийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг институц зохион байгуулдаг бөгөөд нэр дэвшигчдийн оролцооны түвшин нь тухайн улсын улс төрийн соёлын онцлог, институцийн зохион байгуулалтын загвараас хамааран харилцан адилгүй байна.

Ардчилсан улс орнуудын хувьд, телевизээр шууд дамжуулдаг мэтгэлцээнүүд нь нийтлэг шинж чанартай. Тухайлбал, тэдгээр нь сонгогчдод нэр дэвшигчдийн үзэл баримтлал, бодлогын санал, улс төрийн манлайллын талаар илүү тодорхой ойлголт өгөх, улмаар сонгуулийн өдөр оновчтой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг. Гэвч мэтгэлцээний бүтэц, зохион байгуулалт, зохион байгуулагч талууд, мөн улс төрийн оролцооны соёл нь улс бүрт өөр өөрийн өвөрмөц онцлогтой.

Энэхүү судалгаанд Австрали, АНУ, Герман, Их Британи, Мексик, Солонгос болон Япон Улсын туршлагын талаар тодруулан авч үзэв[1].

1.1.Австрали

Австралийн холбооны сонгуулийн үеэр мэтгэлцээнийг хуульчилж заавал зохион байгуулах эрх зүйн шаардлага байдаггүй. Мэтгэлцээнийг улс төрийн намууд, нэр дэвшигчид болон өргөн нэвтрүүлгийн байгууллагууд хооронд хэлэлцэн тохиролцож явуулдаг бөгөөд энэ нь хэлбэр загвар, тоо, дамжуулах сувгийн хувьд кампанит ажлаас хамаарч өөр өөр байдаг. Тухайлбал, 1993, 2013, 2016, 2019, 2022 оны холбооны сонгуулиудад гурван удаагийн мэтгэлцээн зохион байгуулагдсан бол 1990, 1998, 2001, 2007, 2010 оны холбооны сонгуулиудад тус бүр нэг удаа зохион байгуулжээ[2].

1.2.АНУ

АНУ-д 1987 онд байгуулагдсан Ерөнхийлөгчийн мэтгэлцээний комисс (Commission on Presidential Debates, CPD)[3] нь ашгийн бус, намаас хараат бус байгууллага бөгөөд засгийн газар, улс төрийн нам, нэр дэвшигчдээс санхүүжилт авдаггүй. Тус байгууллагын үндсэн зорилго нь АНУ-ын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн мэтгэлцээнийг тогтмол зохион байгуулж, сонгогчийн мэдээлэлтэй сонголтыг дэмжих юм. Комисс 1988-2020 оны АНУ-ын бүх ерөнхий сонгуулийн мэтгэлцээнийг зохион байгуулсан[4]. 2024 оны мэтгэлцээнийг Ерөнхийлөгчийн мэтгэлцээний комисс бус сүлжээ телевизүүд зохион байгуулсан.

---

[1] Канад: Debates around the world, Хандах https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm Хандсан: 2025-06-25

[2] Австрали: Leadership change, policy issues and voter defection in the 2010 Australian election, 2012, Хандах https://australianelectionstudy.org/wp-content/uploads/McAllister-Bean-Pietsch-Leadership-Change-2012.pdf Хандсан: 2025-06-25

[3] АНУ: The Commission on Presidential Debates: An overview, Хандах https://debates.org/about-cpd/overview/?utm_source, Хандсан: 2025-08-29

[4] АНУ: The commission of Presidential Debates. Хандах http://debates.org/, Хандсан: 2025-06-25

АНУ-ын Холбооны сонгуулийн комисс (Federal Election Commission, FEC)-ийн Холбооны зохицуулалтын код (code of federal regulation)-ийн 11-ийн 110.13 дугаар зүйлд[5] нэр дэвшигчдийн мэтгэлцээн зохион байгуулах байгууллага, мэтгэлцээний бүтэц болон нэр дэвшигчийг сонгох шалгуурын талаар зохицуулсан. Энэхүү кодод ашгийн бус этгээд, өргөн нэвтрүүлгийн байгууллагууд мэтгэлцээн зохион байгуулж болно гэж заасан.

Ерөнхийлөгчийн мэтгэлцээний комисс 2000 оноос эхлэн үндэсний 5 санал асуулгын дунджаар 15 хувиас дээш дэмжлэг авсан байх шалгуурыг баталсан бөгөөд энэ босгыг хангасан нэр дэвшигч Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээнд оролцох боломжтой болсон.

Ерөнхийлөгчийн мэтгэлцээний комисс нь мэтгэлцээний форматыг тодорхойлох, хөтлөгчийг сонгох үүрэгтэй бөгөөд 1996 оноос хойш (нэг удаагийн онцгой тохиолдлоос бусад) бүх мэтгэлцээнийг нэг хөтлөгч хөтөлсөн бөгөөд хөтлөгч сонгоход дараах гурван шалгуурыг харгалздаг:

- нэр дэвшигчид болон кампанит ажлын гол асуудлуудыг сайн мэддэг байх;
- шууд нэвтрүүлгийн телевизийн мэдээний туршлагатай байх;
- мэтгэлцээндий үеэр нэр дэвшигчид болон тэдний үзэл бодолд хамгийн их цаг, анхаарал хандуулах зарчмыг баримталдаг байх.

Комиссын сонгосон хөтлөгчид мэтгэлцээний сэдэв, асуултыг дангаар тодорхойлдог байна[6].

1.3.Герман

Германд сонгуулийн мэтгэлцээнийг заавал зохион байгуулахыг хуульчилсан тусгайлсан зохицуулалт байхгүй. Иймээс мэтгэлцээнүүд нь улс төрийн намууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулагддаг.

Тус улсын сонгуулийн компанит ажлын үеийн телевизийн мэтгэлцээний уламжлал нь үндсэндээ хоёр өөр хэлбэртэй.

- Олон намын удирдлагуудын хамтарсан телевизийн мэтгэлцээн. 1972 оноос олон нийтийн хоёр телевиз ARD ба ZDF хамтран тогтмол зохион байгуулж, сонгуулийн өмнөх өдрүүдэд шууд дамжуулж эхэлсэн[7].
- Канцлерт нэр дэвшигчдийн хоорондох хоёр хүний телевизийн мэтгэлцээн. 2002 оноос “TV-Duell” нэртэй эхэлж, Холбооны канцлерт өрсөлдөж буй хоёр гол намын нэр дэвшигч оролцдог болсон. Канцлер Ангела Меркелийн удирдсан үеийн сонгуулиудад (2005-2021) дөрвөн телевизийн суваг хамтран сонгууль бүрт нэг удаагийн хамтарсан мэтгэлцээнийг зохион байгуулж байсан.

Харин 2021 онд Канцлерт нэр дэвшигчдийн хоорондох мэтгэлцээнд гурван гол нэр дэвшигч оролцсон гурван цуврал мэтгэлцээнийг олон нийтийн болон хувийн телевизийн сүлжээнүүдээс зохион байгуулсан. Түүнчлэн сонгуулийн өмнөх сүүлийн гурван хоногт

[5] АНУ: § 110.13 Candidate debates, Хандах https://www.ecfr.gov/current/title-11/chapter-I/subchapter-A/part-110/section-110.13?utm

[6] АНУ: Debates around the world, Хандах https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm Хандсан: 2025-08-04

[7] Герман: Vier Tage vor der Wahl – 1972, Хандах https://www.bpb.de/mediathek/video/340218/vier-tage-vor-der-wahl-1972/?utm, Хандсан: 2025-09-08

Бундестагийн долоон намын төлөөлөл оролцсон уламжлалт “эцсийн мэтгэлцээн”-ийг (1972 оноос уламжилсан хэлбэр) ARD-болон ZDF-ээр дамжуулан явуулсан[8].

1.4.Их Британи

Их Британи Улсад 2010 оноос хойш мэтгэлцээн нь бүх нийтийн сонгуулийн компанит ажлын гол онцлог болсон бөгөөд телевизийн мэтгэлцээний зохион байгуулалтыг хянах үүрэг бүхий төв байгууллага, эрх зүйн тогтолцоо байдаггүй.

Мэтгэлцээнийг ихэвчлэн үндэсний томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд зохион байгуулдаг. Тэд тус улсын хэвлэл мэдээллийн зохицуулагч “Ofcom”-оос тогтоосон шударга байдлын дүрмийг дагаж мөрдөн улс төрийн намуудтай шууд хэлэлцээ хийж, оролцоо болон хэлэлцүүлгийн хэлбэрийг тохиролцдог.

Их Британи Улсад 2015, 2017, 2019 онуудад болон 2024 оны бүх нийтийн сонгуулиар мэтгэлцээн зохион байгуулагдсан. Тус улсад сонгууль бүрд мэтгэлцээн заавал зохион байгуулах талаар урьдчилан тогтсон эрх зүйн зохицуулалт, тогтвортой жишиг байхгүй тул тухайн сонгуулийн нөхцөл байдал, оролцогч нам, нэр дэвшигчдийн шийдвэрээс хамааран мэтгэлцээн зохион байгуулах эсэх нь тодорхой бус, урьдчилан таамаглах боломжгүй хэвээр байна[9].

1.5.Мексик

Мексик Улс нь Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээнийг 2006 оноос хойш тус улсын бие даасан сонгуулийн байгууллага болох Үндэсний Сонгуулийн Хүрээлэн (National Electoral Institute (INE))[10] зохион байгуулж ирсэн бөгөөд мэтгэлцээн хариуцсан комисстой. Тус комисс нь холбооны болон орон нутгийн сонгуулийг зохион байгуулж, улс төрийн үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ сонгуультай холбоотой асуудлаар үндсэн эрх мэдлийг хэрэгжүүлдэг.

Тус комисс нь Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж буй бүх нэр дэвшигчийн хооронд хоёроос доошгүй удаа мэтгэлцээн зохион байгуулдаг бөгөөд нэр дэвшигчид нь эдгээр мэтгэлцээнд заавал оролцох үүрэггүй. Комисс нь 2006 оноос хойш мэтгэлцээний форматыг бүрэн тодорхойлох эрхтэй болж, мэтгэлцээний асуултыг мэтгэлцээний хөтлөгчид бэлтгэдэг бөгөөд хоёр удаагийн мэтгэлцээнийг төрийн болон хувийн олон нийтийн радио, телевизээр дамжуулдаг[11].

1.6.Солонгос

Солонгос Улсын Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн[12] 8-7, 82-2, 82-3 дугаар зүйлд зааснаар Үндэсний сонгуулийн өргөн нэвтрүүлгийн мэтгэлцээний хороо (National Election Broadcasting Debate Commission) нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд Ерөнхийлөгчийн сонгууль болон Үндэсний Ассамблейн пропорционал төлөөллөөр сонгогдох гишүүдийн мэтгэлцээнийг хариуцан зохион байгуулна.

---

[8] Герман: Debates around the world, Хандах https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm Хандсан: 2025-08-04

[9] Их Британи: Debates around the world, Хандах https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm Хандсан: 2025-06-25

[10] Мексик: National Electoral Institute. Хандах https://ine.mx/sobre-el-ine/, Хандсан: 2025-08-05

[11] Мексик: Debates around the world, Хандах https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm

[12] Солонгос: Public Official Election act (1994/2025), Хандах https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53845&lang=ENG

Пропорционал төлөөллөөр сонгогдох гишүүний мэтгэлцээнийг Үндэсний сонгуулийн нэвтрүүлгийн мэтгэлцээний хороо хоёроос доошгүй удаа зохион байгуулах бөгөөд мэтгэлцээнд улс төрийн намын төлөөллөөс томилсон нэг буюу хэд хэдэн нэр дэвшигчийг оролцуулдаг.

Бүх шатны сонгуулийн хороо нь бодлогын мэтгэлцээнийг шударгаар зохион байгуулах, явуулах зорилгоор сонгуулийн нэвтрүүлгийн мэтгэлцээний хороог байгуулах бөгөөд мэтгэлцээнд шалгуур хангасан нэр дэвшигчдийг урьж оролцуулна. Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 82-2 дугаар зүйлд зааснаар урилгаар оролцохоор болсон нэр дэвшигч нь үндэслэлгүйгээр оролцохоос татгалзах ёсгүй бөгөөд мэтгэлцээнд оролцох нэр дэвшигч нь дараах шалгуурыг хангасан байна гэж заасан. Үүнд:

- пропорционал төлөөллөөр сонгогдох сонгууль – Үндэсний Ассамблейд 5 ба түүнээс дээш суудалтай, эсхүл хамгийн сүүлд болсон Ерөнхийлөгчийн сонгууль, пропорционал төлөөлөгчдийн сонгуулиар 3 хувь ба түүнээс дээш санал авсан намын нэр дэвшигч;
- тойргийн гишүүний сонгууль – дээр дурдсан нэр дэвшигчээс гадна сүүлийн 4 жилийн хугацаанд тухайн тойрогт 10 хувиас дээш санал авсан нэр дэвшигч, санал хураалтын өмнөх 30 хоногийн дотор олон нийтийн санал асуулгаар 5 ба түүнээс дээш хувийн дэмжлэг хүлээсэн нэр дэвшигч байна.

Дээр дурдсан шалгуурт хамаарахгүй нэр дэвшигчдэд зориулсан мэтгэлцээнийг тусад нь зохион байгуулж болно. Хуулийн 82-2 (6) дугаар зүйлд мэтгэлцээнд оролцох урилга авсан ч үндэслэлгүйгээр оролцоогүй нэр дэвшигчийн нам, нэр, дугаар, оролцоогүй тухай мэдээллийг олон нийтэд зарлаж, Сонгуулийн ерөнхий хорооны журамд зааснаар цахим хуудаст нийтэлнэ. Олон нийтийн болон тухайн нутаг дэвсгэрийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд нь мэтгэлцээнийг өөрсдийн зардлаар шууд дамжуулна. Хэрэв дээрх байгууллагууд шууд дамжуулалт хийх боломжгүй бол тухайн орон нутгийн сонгуулийн хороо бусад кабелийн телевизээр дамжуулах бөгөөд зардлыг нь улсын болон орон нутгийн захиргаа хариуцахаар хуулийн 82-2 дугаар зүйлийн 10, 11 дэх хэсэгт заасан байна.

Үндэсний сонгуулийн өргөн нэвтрүүлгийн мэтгэлцээний хороо нь дараах төрлийн мэтгэлцээнүүдийг зохион байгуулдаг[13]. Хүснэгт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 1 Солонгосын Үндэсний сонгуулийн өргөн нэвтрүүлгийн мэтгэлцээний хорооноос зохион байгуулдаг мэтгэлцээний төрлүүд

Комиссын түвшин	Төрөл	Сонгууль	Мэтгэлцээний цаг хугацаа	Хэдэн удаа	Холбогдох хууль
Үндэсний	Нэр дэвшигчдийн мэтгэлцээн	Ерөнхийлөгчийн сонгууль	Сурталчилгааны хугацаанд	Гурав ба түүнээс дээш	Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 82-2
		Үндэсний Ассамблейн пропорциональ гишүүдийн сонгууль	Сурталчилгааны хугацаанд	Хоёр ба түүнээс дээш	
	Нийтийн албаны сонгуулийн	Бүрэн эрхийн хугацаа нь	Сонгуулийн өдрөөс 90 хоногийн өмнө	Сард нэг удаа ба	Нийтийн албан тушаалтны

[13] Солонгос: Election Broadcasting Debates, Хандах https://www.nec.go.kr/site/eng/01/10103030000002020070611.jsp?utm# , Хандсан: 2025-09-08

	бодлогын мэтгэлцээн	дууссаны дараа болсон сонгууль	нэр дэвшигчийг бүртгэхээс нэг өдрийн өмнө	түүнээс дээш	сонгуулийн тухай хуулийн 82-3
	Улс төрийн намын бодлогын мэтгэлцээн	Жилийн турш	Сонгууль болохоос 90 хоногоос өмнөх бусад хугацаанд	Жилд хоёр ба түүнээс дээш	Улс төрийн намын тухай хуулийн 39 дүгээр зүйл
Ши/Ду[14]	Нэр дэвшигчдийн мэтгэлцээн	Ши/Дугийн тэргүүн, Ши/Дугийн зөвлөлийн пропорциональ төлөөллийн гишүүдийн сонгууль	Сурталчилгааны хугацаанд	Тус бүр нэг удаа буюу түүнээс дээш	Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 82-2
Гу/Си/Гүн	Нэр дэвшигчдийн мэтгэлцээн, сонгуулийн сурталчилгааны хамтарсан уулзалтууд	Үндэсний Ассамблейн орон нутгийн төлөөлөгч, Гу/Си/Гүнийн Засаг дарга нарын сонгууль	Сурталчилгааны хугацаанд	Тус бүр нэг удаа буюу түүнээс дээш	

Эх сурвалж: БНСУ-ын Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас, https://www.nec.go.kr/site/eng/01/10103030000002020070611.jsp?utm#

1.7.Франц

Франц Улс Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёдугаар шатны нэр дэвшигчдийн телевизийн мэтгэлцээнийг анх 1974[15] онд зохион байгуулсан бөгөөд түүнээс хойш мэтгэлцээн нь уламжлал болон төлөвшсөн. Энэ нь хуульд заасан заавал биелүүлэх үүрэг биш, нэр дэвшигчдийн сайн дурын оролцоо, телевизийн сувгуудын санаачлага, хамтран зохион байгуулалт дээр тулгуурладаг.

Франц улсын дуу дүрс, дижитал харилцаа холбооны зохицуулах газар (l'Arcom) нь улс төрийн үзэл бодлын олон ургальч байдлыг хамгаалж, радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрүүдэд улс төрийн хүчнүүдийн дуу хоолой тэнцвэртэй тусгагдах нөхцөлийг хянах гол үүрэгтэй. Харин мэтгэлцээний формат, зохион байгуулалтыг телерадиогийн редакц, нэр дэвшигчид тохиролцдог.

Ерөнхийлөгчийн сонгуулийн үед l'Arcom-аас баталсан зөвлөмж, шийдвэрүүдийг үндэслэн телевиз, радио "яриа болон эфирийн хугацаа"-ны тэнцвэрийг баримтлах бөгөөд нэр дэвшигч бүрт ижил нөхцөл, ижил хугацаа олгоно гэж заасан[16].

[14] Солонгосын орон нутгийн засаг захиргаа нь орон нутгийн өөртөө засах өргөтгөсөн нэгж, өөртөө засах үндсэн нэгж гэж хуваадаг. Ши/Ду нь өөртөө засах өргөтгөсөн нэгж, Гу/Си/Гүн өөртөө засах үндсэн нэгжид хуваагддаг. Ши нь өргөтгөсөн хот, Ду нь муж, Гу нь дүүрэг, Си нь хот, Гүн нь хошуу/сум гэж ойлгоно. Д.Сайнбилэгт, БНСУ-ын улс төрийн тогтолцоо, 2008, 92 дахь тал

[15] Франц: Présidentielles 1974-2022: les débats télévisés entre les deux tours, Хандах https://www.vie-publique.fr/discours-dans-lactualite/269522-presidentielles-1974-2022-les-debats-televises-entre-les-deux-tours?utm_source Хандсан: 2025-08-27

[16] Франц: Ерөнхийлөгчийг сонгохтой холбогдуулан Дуу дүрс бичлэгийн дээд зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 2021-03 дугаартай аудиовизуал харилцааны үйлчилгээнд өгөх зөвлөмж, Хандах https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000044235318?utm_source, Хандсан: 2025-08-27

ХОЁР. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ШТАБЫН АЖИЛТНУУДЫН ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛЛЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

Сонгуулийн сурталчилгааны үеэр төлбөртэй ухуулагч ажиллуулахыг хуульчлан хориглосон цөөн улс байна. Ийм зохицуулалт нь сонгуулийн шударга бус байдал, мөнгөний нөлөөг хязгаарлах зорилготой.

Энэ талаар Их Британи, Солонгос, Япон Улсын эрх зүйн зохицуулалтын талаар авч үзэв.

2.1.Их Британи

Их Британи Улсад Ард түмний төлөөллийн тухай хуулийн[17] 111 дүгээр зүйлд хэрвээ хувь хүн сонгуулийн өмнө, явцад эсхүл дараа нэр дэвшигчийн сонгуульд ялалт байгуулахыг дэмжих, хангах зорилгоор төлбөртэй, эсхүл төлбөрийн амлалтаар сонгуулийн сурталчилгааны ухуулагчаар ажилд орсон, эсхүл ажиллуулсан бол хариуцлага тооцохоор заасан.

Харин Сонгуулийн комиссын цахим хуудас дахь мэдээллээр нам бус ухуулагч ажиллахыг зөвшөөрдөг. Нам бус ухуулагч гэдэг нь улс төрийн намд бүртгэлгүй, сонгуульд нэр дэвшээгүй зарим хувь хүн, байгууллага улс төрийн нам, нэр дэвшигчийн төлөө, эсхүл эсрэг, сонгууль тойрсон асуудлаар сурталчилгаа явуулдаг бөгөөд Сонгуулийн хуульд гуравдагч этгээд гэж тодорхойлсон боловч Сонгуулийн комисс нам бус ухуулагчид гэж нэрлэдэг[18].

Нам бус ухуулагч нь орон нутгийн болон парламентын бүх нийтийн сонгуулийн ухуулагч гэсэн хоёр төрөлтэй. Нам бус ухуулагч нь аль нэг нам эсхүл тодорхой бодлогыг дэмжиж эсхүл дэмжихгүй байгаагаа илэрхийлсэн арга хэмжээ зохион байгуулдаг. Парламентын бүх нийтийн сонгуулийн сурталчилгааг 2000 онд батлагдсан Улс төрийн нам, сонгууль, бүх нийтийн санал асуулгын тухай хууль (Political parties, Elections and Referendums act)[19]-иар зохицуулдаг.

Нам бус ухуулагч нь Зардал ба хандивын тухай хуульд заасны дагуу Их Британи Улсад амьдардаггүй, сонгогчдын бүртгэлд бүртгэгдээгүй, нам бус ухуулагчаар бүртгүүлээгүй, парламентын ерөнхий сонгуулийн өмнө компанит ажил явуулдаг бол энэ төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хэрэв нам бус ухуулагчийн үйл ажиллагаа явуулах зардал нь 700 фунт стирлингээс бага бол хуульд заасан тайлан гаргахгүй[20] ба нам бус ухуулагчийн үйл ажиллагаа явуулж буй сонгуулийн тойргийн зардлын хязгаараас хэтэрсэн хэмжээний

---

[17] Их Британи: Representation of the People Act (1983/2016), Хандах https://www.legislation.gov.uk/ukpga/1983/2/section/111

[18] Их Британи: The Electoral Commission Non-party campaigner. Хандах https://www.electoralcommission.org.uk/non-party-campaigners-uk-parliamentary-general-elections/what-a-non-party-campaigner Хандсан: 2025-07-05

[19] Их Британи: Political parties, Elections and Referendums act (2000/2022), Хандах https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/section/85

[20] Их Британи: The Electoral Commission Non-party campaigner. Хандах https://www.electoralcommission.org.uk/non-party-campaigners-uk-parliamentary-general-elections/what-a-non-party-campaigner Хандсан: 2025-07-05

зардал гаргасан бол сонгуулийн дараа хандивын тайлан, зарцуулалтын тайлангаа Сонгуулийн комисст ирүүлэх ёстой.

2.2.Солонгос

Солонгос Улс нь ухуулагчдыг бүрэн хориглоогүй, харин бүртгэгдсэн кампанит ажлын багийн гишүүд сурталчилгаа явуулж болох бөгөөд Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулиар[21] ухуулагчдын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг.

Тус хуулийн 135 дугаар зүйлд зааснаар ухуулагчид нь зөвхөн албан ёсны сурталчилгааны хугацаанд ажиллана. Сонгуулийн сурталчилгааны ажилтанд дараах этгээдүүд хамаарна. Үүнд:

- сонгуулийн сурталчилгааны менежер;
- сурталчилгааны албаны дарга;
- сурталчилгааны ажилтан, туслах;
- нягтлан бодогч.

Тус хуулийн 135 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгааны ажилтнуудад урамшуулал болон гарсан бодит зардлыг нөхөн төлж болох бөгөөд дараах тохиолдолд зөвхөн бодит зардлыг нөхөн олгоно. Үүнд:

- улс төрийн намын цалинтай ажилтан;
- Үндэсний Ассамблейн гишүүн, түүний туслах, ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга;
- орон нутгийн төлөөлөгчийн байгууллагын гишүүн зэрэг албан тушаалтнууд нь дээр дурдсан сурталчилгааны албан тушаалыг давхар хашиж байгаа бол.

Тус хуулийн 135 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгааны ажилтнуудад олгох урамшуулал (нэг өдрөөр), бодит зардлыг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

- Ерөнхийлөгчийн сонгууль болон пропорционал сонгуулийн сурталчилгааны менежер 140.000 вон хүртэл (99.8 ам.доллар)[22];
- пропорционал тогтолцоотой хот/аймгийн зөвлөлийн гишүүний сонгууль болон хот/аймгийн засаг даргын сонгуулийн сурталчилгааны менежер, ерөнхийлөгчийн сонгуулийн хот/аймгийн сонгуультай харилцах албаны дарга 140.000 вон хүртэл; Үндэсний Ассамблейн сонгуулийн орон нутгийн тойрог болон өөртөө засах дүүрэг/хот/суурингийн захирагчийн сонгуулийн сурталчилгааны менежер, ерөнхийлөгчийн сонгууль, хот/амйгийн засаг даргын сонгуулийн ажлын албаны дарга 100.000 вон хүртэл (71 ам.доллар);
- орон нутгийн хот/аймгийн зөвлөлийн сонгуулийн сурталчилгааны ажилчид/туслахууд 60.000 вон хүртэл (43 ам.доллар);
- нягтлан бодох бүртгэлийн менежер нь харьяалах сонгуулийн сурталчилгааны менежер, сонгуулийн ажлын албаны даргын цалинтай ижил байна.

Мөн зүйлд хэн ч сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор ямар ч нэрээр (урамшуулал, бодит зардлын нөхөн төлбөр, сайн дурын ажилтанд олгох урамшуулал гэх мэт) мөнгө, эд зүйлс, бусад эдийн болон эдийн бус ашиг тус санал болгох, санал

[21] Солонгос: Public Official Election act (1994/2025), Хандах https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53845&lang=ENG

[22] МонголБанкны 2025.08.04-ний өдрийн ханшаар тооцоолов. 1 ам доллар 3589 төгрөг, 1 вон 2.56 төгрөг

болгохоо илэрхийлэх, амлах, даалгах, ятгах, зуучлах, шаардах, хүлээн авах үйлдэл хийхийг хориглоно.

2.3.Япон

Япон Улс сонгуулийн ухуулагчид цалин, урамшуулал олгохыг ерөнхийдөө хориглодог бөгөөд сайн дурын, төлбөргүй оролцоо гэсэн дүрмийг баримталдаг хэдий ч Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 197-2 дугаар зүйлд[23] тодорхой хязгаарлагдсан ангилалын хүмүүст, хуульд заасан нөхцөл, хязгаарт багтаан нөхөн төлбөр, урамшуулал олгохыг зөвшөөрсөн. Тодруулбал, Төлөөлөгчдийн танхим (пропорционал төлөөллийн)-ын гишүүний сонгуулиас бусад сонгуульд сонгуулийн кампанит ажилд оролцогчдод төлж болох урамшуулал болон бодит зардлын нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын тогтоохоор заасны дагуу Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 227 дугаар тогтоолоор Нийтийн албан тушаалтны

[23] **197-2 дугаар зүйл (Бодит зардлын нөхөн төлбөр ба урамшууллын хэмжээ)**

1. Төлөөлөгчдийн танхимын (пропорциональ төлөөллөөр сонгогдох) гишүүний сонгуулиас бусад сонгуулийн үед сонгуулийн сурталчилгаанд (Төлөөлөгчдийн танхимын жижиг тойргийн сонгуулийн үед нэр дэвшигчийг дэвшүүлсэн намын явуулсан сонгуулийн сурталчилгаа болон Зөвлөхүүдийн танхимын пропорциональ төлөөллийн сонгуулийн үед намын нэрсийн жагсаалт ирүүлсэн байгууллагын явуулсан сурталчилгааг үл хамаарна. Энэ хэсэг болон дараагийн хэсгүүдэд адил.) оролцогчид олгох бодит зардлын нөхөн төлбөр, түүнчлэн сонгуулийн сурталчилгаанд ажиллуулсан ажилтнуудад олгох урамшуулал болон бодит зардлын нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын тогтоосон стандартад нийцүүлэн тухайн сонгуулийн ажиллагааг эрхэлсэн сонгуулийн удирдах хороо (Зөвлөхүүдийн танхимын пропорциональ төлөөллийн сонгуулийн хувьд Төв сонгуулийн удирдах хороо, Зөвлөхүүдийн хамтарсан сонгуулийн хувьд хамтарсан сонгуулийн удирдах хороо) тогтооно.
2. Төлөөлөгчдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулиас бусад сонгуулийн үед сонгуулийн сурталчилгаанд оролцогч (зөвхөн 141 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу сурталчилгаанд ашиглагдах автомашин, хөлөг онгоцон дээр ажиллах ажилтан; дохионы хэлний орчуулагч; мөн 142-3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу цахим хуудсаар сурталчилгаанд хэрэглэгдэх материалыг түгээх; эсхүл 143 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу сурталчилгаанд хэрэглэгдэх материалыг байрлуулах зорилгоор ярианы тэмдэглэл хөтлөх ажилтан [цаашид “хураангуй тэмдэглэл хөтлөгч” гэх])-д, дээр дурдсан бодит зардлын нөхөн төлбөрөөс гадна нэр дэвшигчийн бүртгэлийн өдрөөс (86 дугаар зүйлийн 1–3, 8 дахь хэсэг, мөн 86-2, 86-3, 86-4 дэх зүйлд заасны дагуу) сонгуулийн өдөр хүртэлх хугацаанд, нэг нэр дэвшигчийн хувьд өдөрт 50-аас хэтрэхгүй хүнийг, Засгийн газраас тогтоосон дээд хязгаарын хүрээнд, нэг хүнд өдөр тутмын урамшууллыг Засгийн газрын тогтоосон стандартын дагуу тухайн сонгуулийн удирдах хороо тогтоон олгож болно.Төлөөлөгчдийн танхимын (жижиг тойргоос сонгогдох) сонгуулийн үед нэр дэвшигчийг дэвшүүлсэн нам нь, өөрийн явуулж буй сурталчилгаанд оролцогч (зөвхөн 141 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу автомашин, хөлөг онгоцон дээр ажиллах ажилтан, зөвхөн дохионы хэлний орчуулагч, зөвхөн хураангуй тэмдэглэл хөтлөгч)–д, тухайн сонгуулийн бүртгэлийн өдрөөс сонгуулийн өмнөх өдөр хүртэлх хугацаанд, нэг хүнд өдөр бүрийн урамшууллыг Засгийн газрын тогтоосон хэмжээгээр олгож болно.
3. Төлөөлөгчдийн танхимын (пропорциональ төлөөллөөр сонгогдох) сонгуулийн үед нэрсийн жагсаалт ирүүлсэн улс төрийн нам болон бусад байгууллага нь, өөрийн явуулж буй сурталчилгаанд оролцогч (зөвхөн 141 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дагуу автомашин, хөлөг онгоцон дээр ажиллах ажилтан, зөвхөн дохионы хэлний орчуулагч, хураангуй тэмдэглэл хөтлөгч)–д, нэр дэвшигчийн бүртгэлийн өдрөөс сонгуулийн өмнөх өдөр хүртэлх хугацаанд, өдөр бүрийн урамшууллыг Засгийн газраас тогтоосон хэмжээгээр олгож болно.
4. 2 дахь хэсгийн дагуу урамшуулал авах этгээд нь, нэр дэвшигчтэй ажиллахын өмнө (хэрэв урьдчилан бүртгүүлэх боломжгүй тохиолдолд урамшуулал олгохоос өмнө) Засгийн газрын тогтоосон журмын дагуу тухайн сонгуулийн зохион байгуулж буй сонгуулийн удирдах хороонд (Зөвлөхүүдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулийн хувьд Төв сонгуулийн удирдах хороо, олон мандаттай тойргийн хувьд хамтарсан сонгуулийн удирдах хороо) бүртгүүлсэн байх ёстой.

сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай журамд өөрчлөлт оруулж, сонгуулийн сурталчилгаанд оролцож буй хүмүүст олгох нөхөн төлбөр, урамшууллын хэмжээг дараах байдлаар шинэчлэн баталсан[24]. Үүнд:

Хүснэгт 2 Японы сонгуулийн сурталчилгаанд оролцогчдод олгох бодит зардлын нөхөн төлбөрийн хэмжээ (нэг өдрөөр)

	Өөрчлөлт оруулахаас өмнө	**Өөрчлөлт оруулсны дараа**	**Монгол төгрөгт шилжүүлснээр[25]**
Байрны төлбөр	Нэг шөнийн 12.000 иен (2 хоол багтсан)	Нэг шөнийн 23.000 иен (2 хоол багтсан)	Нэг шөнийн 560280 төгрөг
Үдийн хоолны төлбөр	Нэг хоол 1000 иен Өдөрт 3000 иен	Нэг хоол 1500 иен Өдөрт 4500 иен	Нэг хоол 36540 төгрөг Өдөрт 109620 төгрөг
Цай, хөнгөн зууш	Өдөрт 500 иен	Өдөрт 1000 иен	Өдөрт 24360 төгрөг

Хүснэгт 3 Японы сонгуулийн сурталчилгаанд оролцогчдод олгох урамшууллын хэмжээ (нэг өдрөөр)

	Өөрчлөлт оруулахаас өмнө	**Өөрчлөлт оруулсны дараа**	**Монгол төгрөгт шилжүүлснээр**
Оффисийн ажилтан	10.000 иен	15.000 иен	365400 төгрөг
автомашин/усан онгоцны ажилтан	15.000 иен	20.000 иен	487200 төгрөг
дохионы хэлний хэлмэрч	15.000 иен	20.000 иен	487200 төгрөг
хураангуй бичвэр хийгч	15.000 иен	20.000 иен	487200 төгрөг

Хүснэгт 4 Японы сонгуулийн сурталчилгааны туслах ажилтанд олгох мөнгөн дүнгийн хэмжээ (Бодит зардлын нөхөн төлбөр, нэг шөнөөр)

	Өөрчлөлт оруулахаас өмнө	**Өөрчлөлт оруулсны дараа**	**Монгол төгрөгт шилжүүлснээр**
Байрны төлбөр	Нэг шөнийн 10.000 иен (хоол ороогүй)	Нэг шөнийн 20.000 иен (хоол ороогүй)	487200 төгрөг

Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нисэх онгоцны тийзний зардлыг нөхөн төлбөрийн зүйл болгон нэмж зохицуулсан.

[24] Япон: Засгийн газрын 2025 оны 227 дугаар тогтоолын өөрчлөлт, Хандах https://www.soumu.go.jp/senkyo/senkyo_s/news/senkyo/seiken_housou/000182850.html, Хандсан: 2025-07-05

[25] МонголБанкны 2025.09.09-ний өдрийн ханшаар 1 иен 24.36 төгрөгөөр тооцов.

ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭГДСЭН СОНИН СЭТГҮҮЛ ГАРГАДАГ УЛС ОРНУУД

Сонгуулийн сурталчилгааны үеэр нэр дэвшигчдийн мэдээллийг нэгтгэх, сонгогчдод тэгш хүртээмжтэй байдлаар хүргэх зорилгоор зарим улс орнуудын сонгуулийн байгууллагаас албан ёсны сонин, сэтгүүл, товхимол хэвлэн гаргадаг. Эдгээр хэвлэлүүдэд нэр дэвшигчдийн намтар, бодлогын хөтөлбөр, сонгуулийн тойргийн мэдээлэл зэргийг багтаадаг.

Ийм төрлийн албан ёсны сурталчилгааны хэвлэл гаргадаг, түүнчлэн сонгогчдод хүргэх нэгдсэн тогтолцоог бий болгосон Солонгос, Япон улсын талаар авч үзэв.

3.1.Солонгос

Солонгос Улсын хувьд Үндэсний Ассамблейн сонгуульд нэр дэвшигчдийн нэгдсэн сонин сэтгүүл гаргадаггүй бөгөөд нэр дэвшигч хүсэлт гаргаж сонгуулийн сурталчилгааны зураг хуудсыг Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим хуудаст байршуулж цахимаар үзэх боломжийг бүрдүүлдэг.

Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйл[26] (сонгуулийн сурталчилгааны зураг хуудас-Poster), 65 дугаар зүйл[27] (Сонгуулийн сурталчилгааны товхимол-Election Campaign Bulletins)-ээр тусгайлан зохицуулсан. Сонгуулийн сурталчилгааны зураг хуудас нь нэр дэвшигчийн зураг, нэр, саналын хуудсанд бичигдэх дугаар, харьяалагдах улс төрийн намын нэр, ажил мэргэжил, боловсрол болон нэр дэвшигчийн намын бодлого, хөтөлбөр, бусад сурталчилгаанд шаардлагатай мэдээллийг оруулна.

Энэ хуулийн 65 дугаар зүйлд нэр дэвшигч бүр сонгуулийн сурталчилгааны товхимол хэлбэрийн нэг төрлийн сонгуулийн сурталчилгааны эмхэтгэл бэлтгэж болох

---

[26] Солонгос: Public Official Election act (1994/2025), Хандах https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53845&lang=ENG

[27] **65 дугаар зүйл (Сонгуулийн сурталчилгааны товхимол)**

(1) Ерөнхийлөгчийн сонгуульд намын нэр дэвшигч болон Үндэсний Ассабмлей, орон нутгийн төлөөлөгчдийн хурлын пропорциональ жагсаалтын нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн улс төрийн нам нэг төрлийн товхимол хэлбэрийн сонгуулийн сурталчилгааны товхимол хэвлүүлж болно. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблей болон орон нутгийн төлөөлөгчдийн хурлын пропорциональ жагсаалтын нэр дэвшигчдийн сурталчилгааны товхимолд тухайн намын нэр дэвшүүлсэн нэр дэвшигч бүрийн зураг, нэр, боловсрол, намтар орсон байна.

(2) Товхимол хэлбэрийн сурталчилгааны товхимол нь ерөнхийлөгчийн сонгуулийн үед 16-аас ихгүй хуудастай, Үндэсний Ассамблей болон орон нутгийн Засаг даргын сонгуулийн үед 12-оос ихгүй хуудастай, орон нутгийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үед 8-аас ихгүй хуудастай байна. Танилцуулга хэлбэрийн сурталчилгааны товхимол нь нэг хуудастай бөгөөд хоёр талдаа хэвлэж болно.

(3) Сурталчилгааны товхимлын тоо нь тухайн тойргийн өрхийн тоо, гэрээр санал өгөхөөр бүртгүүлэхээр урьдчилан мэдүүлэхээр тооцоологдож буй иргэдийн тоо болон энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хүсэлт гаргагчдын тооны нийлбэрээс хэтрэхгүй байна.

(6) Сонгуулийн сурталчилгааны товхимлыг дараах журмаар хүргүүлж, тараана:

2. Үндэсний Ассамблейн сонгууль болон орон нутгийн төлөөлөгчдийн хурлын гишүүд, орон нутгийн Засаг даргын сонгуулийн үед: нэр дэвшигч бүр нэр дэвшигчийн бүртгэл хаагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор харьяа дүүрэг/сумын сонгуулийн хороонд товхимлоо хүргүүлнэ. Харьяа сонгуулийн хороо товхимлыг хянаж, энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хүсэлт гаргасан хүмүүст сонгуулийн өдрөөс наанадаж 10 хоногийн өмнө шуудангаар илгээнэ.

бөгөөд сонгуулийн сурталчилгааны товхимол нь Ерөнхийлөгчийн сонгуульд 16-аас илүүгүй, Үндэсний Ассамблейн сонгуульд 12-оос илүүгүй хуудас байна гэж заасан.

Зурагт хуудас нь хуульд заасан хэмжээнээс өөр байж болохгүй бөгөөд сонгуулийн байгууллагаас заасан газарт л байршуулна.

3.2.Япон

Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 168-170 дугаар зүйлд[28] сонгуулийн хэвлэлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэ хуульд зааснаар

[28] Япон: Public Offices Election Act (1950/2020), Хандах https://laws.e-gov.go.jp/law/325AC1000000100#Mp-Ch_14

168 дугаар зүйл. (Сонгуулийн эмхэтгэлд нийтлүүлэх хүсэлт)

1. Төлөөлөгчдийн танхимын жижиг тойргийн гишүүн, Зөвлөхүүдийн танхимын тойргийн гишүүн, эсхүл аймаг, мужийн захирагчийн сонгуульд нэр дэвшигч нь өөрийн нэр, намтар, улс төрийн үзэл бодол зэргийг сонгуулийн эмхэтгэлд нийтлүүлэхийг хүсвэл, нийтлэх материалыг (жижиг тойрог болон зөвлөхүүдийн тойргийн гишүүний сонгуулийн хувьд зурагтай хамт) хавсарган, тухайн сонгуулийн зарлагдсан өдрөөс хоёр хоногийн дотор (жижиг тойргийн хувьд зарлагдсан өдөртөө) тухайн сонгуулийн удирдах хороонд бичгээр хүсэлт гаргана.
2. Төлөөлөгчдийн танхимын пропорционал төлөөллөөр сонгогдох гишүүний сонгуульд нэрсийн жагсаалт ирүүлсэн улс төрийн нам нь өөрийн нэр, товч нэр, улс төрийн үзэл бодол, жагсаалтын нэр дэвшигчийн нэр, намтар, сонгогдох эрэмбийн зэрэглэлийг сонгуулийн эмхэтгэлд нийтлүүлэхийг хүсвэл, нийтлэх материалыг хавсарган, тухайн сонгуулийн зарлагдсан өдөртөө Төв сонгуулийн удирдах хороонд бичгээр хүсэлт гаргана.
3. Зөвлөхүүдийн танхимын пропорционал төлөөллөөр сонгогдох гишүүний сонгуульд нэрсийн жагсаалт ирүүлсэн улс төрийн нам нь өөрийн нэр, товч нэр, улс төрийн үзэл бодол, жагсаалтын нэр дэвшигчийн нэр, намтар, зураг зэргийг сонгуулийн эмхэтгэлд нийтлүүлэхийг хүсвэл, нийтлэх материалыг хавсарган, тухайн сонгуулийн зарлагдсан өдрөөс хоёр хоногийн дотор Төв сонгуулийн удирдах хороонд бичгээр хүсэлт гаргана.

169 дүгээр зүйл. (Сонгуулийн эмхэтгэлийг хэвлэх)

1. Зөвлөхүүдийн танхимын олон мандаттай тойргийн сонгуулийн хувьд, өмнөх зүйлийн 1 дэх хэсгийн дагуу өргөдөл гаргасан бол, тухайн тойргийн сонгуулийн удирдах хороо нь нийтлэх материалыг сонгуулийн өдрөөс 11 хоногийн өмнө уг тойрогт багтах аймаг, мужийн сонгуулийн удирдах хороонд хүргүүлнэ.
2. Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулийн хувьд, өмнөх зүйлийн 2 ба 3 дахь хэсгийн дагуу өргөдөл гаргасан бол, Төв сонгуулийн удирдах хороо нийтлэх материалыг:
    - Төлөөлөгчдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулийн үед сонгуулийн өдрөөс 9 хоногийн өмнө,
    - Зөвлөхүүдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулийн үед сонгуулийн өдрөөс 11 хоногийн өмнө, тус тус аймаг, мужийн сонгуулийн удирдах хороонд хүргүүлнэ.
3. Аймаг, мужийн сонгуулийн удирдах хороо нь, өмнөх зүйлд заасан өргөдөл эсхүл дээр дурдсан хуулбарыг хүлээн авсан тохиолдолд нийтлэх материалыг эхээр нь сонгуулийн эмхэтгэлд нийтлэх үүрэгтэй. Энэ үед:
    - Төлөөлөгчдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулийн хувьд тухайн тойргийн нэрсийн жагсаалтын тоонд,
    - Зөвлөхүүдийн танхимын пропорционал төлөөллийн сонгуулийн хувьд жагсаалтын этгээдийн тоонд, харгалзуулан, Дотоод хэргийн яамны журамд заасан хэмжээгээр нийтэлнэ.
4. Төлөөлөгчдийн танхимын сонгуулийн үед жижиг тойргийн болон пропорционал төлөөллийн сонгуулийн эмхэтгэлийг тус тусад нь хэвлэн гаргана.
5. Зөвлөхүүдийн танхимын сонгуулийн үед тойргийн болон пропорционал төлөөллийн сонгуулийн эмхэтгэлийг тус тусад нь хэвлэн гаргана.
6. Хэрэв нэг хуудсан дээр:

Зөвлөхүүдийн танхим (дээд танхим), Төлөөлөгчдийн танхим (доод танхим) болон мужийн захиаргчийн сонгуулийн үед мужийн сонгуулийн удирдах хороо нь нэр дэвшигчийн нэр, зураг, намтар, улс төрийн үзэл баримтлал, улс төрийн намын нэр, нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн этгээдийн нэр, эрэмбийн дугаар зэрэг мэдээллийг багтаасан сонгуулийн эмхэтгэлийг сонгууль бүрт нэг удаа хэвлэн гаргана. Сонгуулийн эмхэтгэлийг тойрог тус бүрээр хэвлэн гаргах бөгөөд зайлшгүй нөхцөл байдлын улмаас бүс нутагт сонгуулийн эмхэтгэлийг хэвлэхгүй байж болох бөгөөд энэ талаарх шийдвэрийг мужийн сонгуулийн удирдах хороо гаргана.

Төлөөлөгчдийн танхимын сонгуулийн үед жижиг тойргийн болон пропорционал төлөөллийн сонгуулийн эмхэтгэлийг тус тусад нь хэвлэн гаргах үүрэгтэй.

Сонгуулийн эмхэтгэлийг мужийн сонгуулийн удирдах хорооноос тогтоосон журмын дагуу сум, тосгон, хотын сонгуулийн удирдах хороо нь тухайн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн өрх бүрт сонгуулийн өдрөөс хоёр хоногийн өмнө тараана. Хэрэв өрх бүрт шууд тараах боломжгүй тохиолдолд, сум, тосгон, хотын сонгуулийн удирдах хороо нь урьдчилан мужийн сонгуулийн удирдах хорооны зөвшөөрөл авч, сонгуулийн эмхэтгэлийг сонины хавсралт эсхүл түүнтэй адил аргаар тарааж болно. Энэ тохиолдолд тухайн хот, тосгон, сумын сонгуулийн удирдах хороо нь эмхэтгэлийг хотын захиргаа, тосгоны захиргаа болон бусад тохиромжтой газарт байрлуулж, сонгогчид уг эмхэтгэлийг хүртээмжтэй байдлаар авах боломжийг хангах ёстой.

- Жижиг тойргийн хоёр ба түүнээс олон нэр дэвшигчийн нэр, намтар, улс төрийн үзэл бодол, зураг;
- Төлөөлөгчдийн танхимын пропорционал төлөөллийн хоёр ба түүнээс олон намын нэр, товч нэр, бодлого болон жагсаалтын нэр дэвшигчийн мэдээлэл;
- Зөвлөхүүдийн танхимын пропорционал төлөөллийн хоёр ба түүнээс олон намын ижил төрлийн мэдээлэл; нийтлэх бол нийтлэх дарааллыг аймаг, мужийн сонгуулийн удирдах хороо сугалаагаар тогтооно.

170 дугаар зүйл. (Сонгуулийн эмхэтгэлийг тараах)

1. Сонгуулийн эмхэтгэлийг аймаг, мужийн сонгуулийн удирдах хорооноос тогтоосон журмын дагуу, сум, тосгон, хотын сонгуулийн удирдах хороо нь тухайн сонгуулийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч бүрийн өрхөд сонгуулийн өдрөөс хоёр хоногийн өмнө тараана.
2. Хэрэв өрх бүрт шууд тараах боломжгүй зайлшгүй нөхцөл байдал гарвал, сум, тосгон, хотын сонгуулийн удирдах хороо нь урьдчилан аймаг, мужийн сонгуулийн удирдах хорооны зөвшөөрөл авч, сонгуулийн эмхэтгэлийг сонгуулийн өдрөөс өмнөх тогтоосон хугацаанд сонинд хавсаргах болон түүнтэй адил аргаар тарааж болно. Энэ тохиолдолд сонгуулийн удирдах хороо нь эмхэтгэлийг иргэдэд хүртээмжтэй байлгахын тулд хот, сумын захиргаа зэрэг газарт байрлуулж, сонгогчид чөлөөтэй авах боломжийг хангана.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Парламентын сонгуулийн кампанит ажлын үеэр нэр дэвшигчид мэтгэлцээнд заавал оролцохыг хуульчилсан улс орон судалсан орнууд дотор байхгүй байна. Гэсэн ч Австрали, Франц, Герман, Мексик, Их Британи, АНУ, Солонгос зэрэг ардчилсан улс орнуудын хувьд мэтгэлцээн нь улс төрийн соёлын салшгүй хэсэг болон төлөвшсөн байна.

Судалгаанд авагдсан улсуудыг авч үзвэл, Мексик, Солонгос улсууд нь мэтгэлцээнийг зохион байгуулах, оролцогчдыг сонгох, шууд дамжуулах асуудлыг хуульчилсан бөгөөд харьцангуй институтийн түвшинд тогтвортой хэрэгжүүлдэг. Харин Австрали, Франц, Герман, Их Британи болон АНУ улсад хэвлэл мэдээллийн байгууллагууд, намуудын хэлэлцээрийн үндсэн дээр зохион байгуулалт хийгддэг. Мэтгэлцээн нь сонгогчдод мэдээлэл өгөх, нэр дэвшигчийн бодлого, байр суурийг харьцуулах чухал хэрэгсэл болдог нийтлэг талтай ч, зохион байгуулагч, субьект, оролцогчийг сонгох шалгуур, оролцох үүрэг, шууд дамжуулах эрх бүхий этгээд болон хууль зүйн үндэс нь улс орон бүрт харилцан адилгүй байна.

Сонгуулийн сурталчилгааны үеэр төлбөртэй ухуулагч ажиллуулахыг хуульчлан хориглосон улсууд цөөн байдаг байна. Энэ нь сонгуулийн шударга байдлыг халах, мөнгөний нөлөөг хязгаарлах зорилготой.

Судалгаанд авагдсан улсуудаас Солонгос улсын хувьд, ухуулагчийг бүрэн хориглоогүй бөгөөд нэр дэвшигчийн кампанит ажлын багийн гишүүнээр ажиллах бөгөөд урамшуулал болон бодит зардлыг олгодог. Харин Япон Улсын хувьд, ухуулагчдыг бүрэн хориглодоггүй, зөвхөн бүртгүүлсэн нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны багт ажиллаж болно. Гэхдээ урамшуулал, бодит зардлыг оффисийн ажилтан, автомашин, усан онгоцны ажилтан, дохионы хэлмэрч, хураангуй бичвэр хийгч гэсэн ажилтнуудад л олгох бөгөөд урамшууллын хэмжээг Засгийн газрын тогтоосноор тооцож олгодог.

Их Британи Улсын хувьд, төлбөртэй ухуулагч ажиллуулахыг хориглодог бөгөөд харин нам бус ухуулагч ажиллахыг зөвшөөрдөг. Нам бус ухуулагч нь улс төрийн намд бүртгэлгүй, сонгуульд нэр дэвшээгүй зарим хувь хүн, байгууллага улс төрийн нам, нэр дэвшигчийн төлөө, эсхүл эсрэг, сонгууль тойрсон асуудлаар сурталчилгаа явуулдаг бөгөөд сонгуулийн байгууллагад бүртгүүлж, санхүүгийн тайлан гаргаж өгөх үүрэгтэй.

Сонгогчдод нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор зарим улс оронд сонгуулийн байгууллагаас албан ёсны сонгуулийн мэдээллийн хэвлэл гаргадаг. Япон Улсад сонгуулийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигчдийн зураг, намтар, бодлогын мэдээллийг багтаасан сонгуулийн сонин хэвлэн, өрх бүрт тараах үүргийг сонгуулийн удирдах хороонд хүлээлгэдэг. Харин БНСУ-д ижил төрлийн сонин, товхимол гаргадаггүй бөгөөд нэр дэвшигч хүсэлт гаргавал зурагт хуудсаа цахим хуудсанд байршуулж болно. Япон нь хуульчилсан, заавал тараах тогтолцоотой бол Солонгос илүү сонголттой, цахим хүргэлтэд тулгуурласан загвартай. Ийнхүү албан ёсны мэдээллийн хүртээмжийг хангах хэлбэр, механизмууд улс орон бүрт харилцан адилгүй боловч сонгогчдын мэдлэгт суурилсан оролцоог дэмжих нийтлэг хандлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ

Австрали:

- Leadership change, policy issues and voter defection in the 2010 Australian election, 2012 https://australianelectionstudy.org/wp-content/uploads/McAllister-Bean-Pietsch-Leadership-Change-2012.pdf

АНУ:

- § 110.13 Candidate debates https://www.ecfr.gov/current/title-11/chapter-I/subchapter-A/part-110/section-110.13?utm
- The Commission on Presidential Debates: An overview https://debates.org/about-cpd/overview/?utm_source
- The commission of Presidential Debates. http://debates.org/

БНСУ:

- Public Official Election act (1994/2025), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53845&lang=ENG
- Election Broadcasting Debates https://www.nec.go.kr/site/eng/01/10103030000002020070611.jsp?utm#

Их Британи:

- Debates around the world. https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm
- Political parties, Elections and Referendums act (2000/2022), https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/section/85
- Representation of the People Act (1983/2016), https://www.legislation.gov.uk/ukpga/1983/2/section/111
- The Electoral Commission (UK), https://www.electoralcommission.org.uk/non-party-campaigners-local-campaigning-great-britain-uk-parliamentary-general-elections-and
- The Electoral Commission Non-party campaigner. https://www.electoralcommission.org.uk/non-party-campaigners-uk-parliamentary-general-elections/what-a-non-party-campaigner

Канад:

- Leaders Debates Commission (Canada) Debates around the world https://www.debates-debats.ca/en/international-research/debates-around-world/index.htm

Мексик:

- National Electoral Institute. Хандах https://ine.mx/sobre-el-ine/
- Constitution (1917/2015) V.Section A. https://www.constituteproject.org/constitution/Mexico_2015

Франц:

- Présidentielles 1974-2022 : les débats télévisés entre les deux tours https://www.vie-publique.fr/discours-dans-lactualite/269522-presidentielles-1974-2022-les-debats-televises-entre-les-deux-tours?utm_source

- Ерөнхийлөгчийг сонгохтой холбогдуулан Дуу дүрс бичлэгийн дээд зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 2021-03 дугаартай аудиовизуал харилцааны үйлчилгээнд өгөх зөвлөмж https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000044235318?utm_source,

Япон:

- Public Offices Election Act (1950/2020) https://laws.e-gov.go.jp/law/325AC1000000100#Mp-Ch_14
- Засгийн газрын 2025 оны 227 дугаар тогтоолын өөрчлөлт https://www.soumu.go.jp/senkyo/senkyo_s/news/senkyo/seiken_housou/000182850.html,